**БАТЛАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН**
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА........................................................................ / Ц.УРАНЧИМЭГ/

**ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН.**
“ӨРНӨХ ГОЛОМТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ........................................................................................./ Л.ГАНХУЯГ/

# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ ОРШИХ “ӨРНӨХ ГОЛОМТ” ХХК-ийн ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НООС, НООЛУУР САМНАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5348013

**ХЯНАСАН:**
Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын

газрын мэргэжилтэн..................................................................../ П.Шинэцэцэг /

**БОЛОВСРУУЛСАН:**
“Өрнөх голомт” ХХК-ийн байгаль орчны

мэргэжилтэн..................................................................................../С.Рэнцэнзоо/

**Улаанбаатар**
**2023**

**АГУУЛГА**


НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА....3

1.2 Төслийн хүчин чадал....4

1.3 Төслийн технологи....4

1.4 Түүхий эд туслах материал....5

1.5 Төслийн усан хангамж....5

1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр....5

1.7 Химийн бодис....5

ХОЁР. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....6

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээий төлөвлөгөөний биелэлт....6

2.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ....8

2.1.2. Дуу чимээнээс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ....12

2.1.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ....12

2.1.4. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ....14

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛЫН БИЕЛЭЛТ....16

ДӨРӨВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....18

ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ....21

ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ....22

6.1. Агаарын шинжилгээ....21

6.2. Усны шинжилгээ....22

6.3.Хөрсний шинжилгээ....23

ДҮГНЭЛТ....254

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| **Төслийн нэр:** | "Ноос, ноолуур самнах үйлдвэр" -ийн төсөл |
| **Төсөл хэрэгжүүлэгч:** | Хувийн хөрөнгө оруулалттай "Өрнөх голомт" ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011454017, Регистрийн дугаар: 5348013 |
| **Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 20-р хороо, 22/4 тоот. Утас: 99019797 |
| **Төслийн байршил:** | Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт 1 га талбайд байрлана. |




Эх үүсвэр: Google earth

*Талбайн байршлын зураг*



*Үйлдвэртйн зураг*

**1.2 Төслийн хүчин чадал**

Ноос, ноолуур самнах үйлдвэр нь боловсруулалт хийгдээгүй түүхий эдийн хэмжээгээр тооцвол хоногт 500 кг, жилд 90 тн ноос, ноолуур самнах хүчин чадалтай ажилладаг. Нийт 27 ажилтантай үүнээс 23 үйлдвэрт 4 ажилтан үйлчилгээнд ажилладаг.

2023 онд 55 тн ноолуур самнан гаргасан.

**1.3 Төслийн технологи**

Үйлдвэр нь австрали улсын технологиор БНХАУ – Шанхай хотод үйлдвэрлэгдсэн ISO 9001 шаардлага хангасан

- 2012 онд үйлдвэрлэгдсэн B210A маркын бутлах машин 1ш
- MDYS 200 маркын багдах машин 1ш
- A186F маркын самнах машин 36ш
- FN288 маркын ялгах 6 ш машинаар тоноглогдсон.




*Ноос ноолуурын самнах үйлдвэрийн технологийн схем*

Үйлдвэрийн технологийн шийдлийн гол зорилт нь ноос, ноолууран түүхий эдийг самнан хялгасыг нь ялгах замаар түүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэн олон улсын стандартын шаардлагад тохирох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаад зах зээлд нийлүүлэх асуудал юм.

### 1.4 Түүхий эд туслах материал

Тус үйлдвэр нь түүхий эд бэлтгэлийг баруун зүгийн засмал замын дагуу орших, Эмээлтийн орчимд өөрийн ноолуур хүлээн авах түрээсийн газраараа дамжуулан бэлтгүүлж, ноолуурыг өнгө, микроноор /дундаж голч/ нь ялган, ялгавартай үнээр худалдан хүлээж авдаг байна.

### 1.5 Төслийн усан хангамж

Үйлдвэрийн хэрэгцээнд ус ашигладаггүй. Ундны усыг 20 литрын баллонтой ус авч ашигладаг.

### 1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр

“Ноос, ноолуур самнах үйлдвэр” нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 –р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Тус үйлдвэр цахилгаан эрчим хүч нэгдсэн шугамд холбогдон хангаж байна. Цагт 6 тн технологийн уур гаргадаг бага оврын дулааны станцын зарчмаар ажиллана. Уурын зуух нь үйлдвэрийг технологийн уураар төдийгүй хэрэглээний халуун ус, дулаанаар хангана. Уурын зуух нь самрын ясаар галладаг.

### 1.7 Химийн бодис

“Өрнөх голомт” ХХК -ийн ноос, ноолуур самнах үйлдвэрт химийн бодис ашигладаггүй.

# ХОЁР. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээий төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| **2.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ** | | | |
| Тус компаний үйлдвэрийн ангилан ялгах, хялгас ялгах гэх мэт зарим цех тасгуудын технологийн процессоос гарах тоосжилт, чимээ шуугиан нь үйлдвэрийн ажлын байрны бохирдолтод нөлөөлөөд зогсохгүй орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болно. | Хатуу болон шингэн хаягдлаар агаар бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авах | Хатуу хог хаягдлын тусгайлсан цементэн хучилттай цэгт үйлдвэрийн хатуу хог хаягдлыг төвлөрүүлэн Сонгинохайрхан дүүргийн ТҮК-тэй байгуулсан гэрээний дагуу нийлүүлж байна.<br>Шингэн хаягдлыг бохирын цооногт хадгалан “Сан гум” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу улиралд 2 удаа соруулдаг. | 100% |
| | Тоосжилт ихтэй хэсэгт /ангилан ялгах ширээний доор/ агааржуулалтын нэмэлт төхөөрөмж тавих | Үйлдвэрийн байранд агааржуулалтын системийг хангалттай хэмжээнд суурилуулан ажиллагааг тогтмол шалгаж байна. | 100% |
| | Агаар дахь хорт боисын хэмжээг ЗДХ-ээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын темпратур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг хянаж, стандартад заасан хэмжээнд байлгах | Агаарын чанар. Техникийн шаардлага MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээг баримтлан ажилладаг ба үйлдвэрээс агаарын чанарын 1 дээж авч шинжлүүлсэн. /Дэлгэрэнгүйг ОХШХ-т тусгав/. | 100% |
| | Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэх | “Энх цагийн үйлс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сард 1 удаа үйлдэрийн талбай, гадна талбайд ариутгал халдвэргүйжүүлэлтийг хийлгэж байна. | 100% |
| | Чимээ ихтэй тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, шинэчлэл хийх арга хэмжээ авах | Тус онд үйддвэрийн тоног төхөөрөмжинд гэмтэл гараагүй болно. | 100% |
| **2.1.2. Дуу чимээний сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ** | | | |
| Ашиглагдаж буй машин тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ | Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх | Бүрэн ханган ажилладаг. | 100% |
| **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ** | | | |
| Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар сөрөг нөлөөлөл үзүүлэх<br><br>Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс газрын доорх ус бохирдох, цэвэрлэх байгууламжийн ажиллагааны горимыг алдагдуулах; | Ус хэрэглээний нормыг цех бүр дээр нарийвчлан тогтоох, түүнд үндэслэн ус ашиглалтын гэрээг холбогдох газартай хийх | Үйлдвэрийн хэмжээнд ус ашигладаггүй ба унд, ахуйн хэрэлээний усыг “Хатан туул”ХХК тай гэрээ байгуулан баллонтой усаар хангадаг | 100% |
| | Үйлдвэрээс гарч буй бохир усанд шинжилгээ хийлгэж, тэмдэглэл хөтөлж байх | Үйлдвэрээс гарсан бохир усыг 60тн 2ш, 10 тн 2ш хэмжээтэй төмөр доторлогоотой бохирын цооногт хадгалан “Сан гум” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу улиралд 2-3 удаа соруулдаг. | 100% |
| | Унд-ахуйн усны чанарт хяналт тавих зорилгоор хими-нян судлалын шинжилгээ хийлгэж байх | Ундны усыг цэвэр ус үйлдвэрлэдэг Хатантуул байгууллагаас авдаг ба тус байгууллагын шинжилгээний дүнг хавсаргав. | 100% |

| **Гол ба болзошгүй сөрөг нөлөө** | **Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ** | **Биелэлт** | **Хувь** |
|---|---|---|---|
| **. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ** | | | |
| Технологийн горимыг зөрчих, ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх;<br><br>Үйлдвэр болон ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох. | Үйлдвэрийн хаягдал бохир ус, угаалгын бодисоор хөрс бохирдож болзошгүй тул хөрсний бохирдлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж байх | ОХШХ тусгав. | 100% |
| | Үйлдвэрийн гадна талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх | Тогтмол хийгдэж байна. | 100% |
| | Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх | Ахуйн хог хаягдлын төвлөрсөн цэгт цуглуулан Сонгинохайрхан дүүргийн ТҮК-тэй байгуулсан гэрээний дагуу сард 1 удаа зайлуулж байна. | 100% |
| | Хатуу хог хаягдлын цэгийг хатуу хучилттай болгох | Хатуу хучилттай болгохоор талбайг бэлтгэх ажил хийгдэж байна. | 0% |

### *2.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ*

Манай үйлдвэр нь тус онд үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарт үүсэх бохирдлыг бууруулахаар дараахь арга хэмжээг авч ажиллаад байна. Үүнд:

1. Хог хаягдлыг гэрээт мэргэжлийн байгууллагад битүү зориулалтын цооногт хадгалан тогтмол нийлүүлж төлбөрийг тухай бүр төлж барагдуулж байна.







ХААН БАНК

Огноо/Date: 2023.06.29 17:24:13

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 30613026

Системийн огноо/System Date:2023.06.29 17:24:03

| | Дансны/Картын дугаар Account/Card number | Нэр/Name | Дүн/Amount | Ханш/Rate |
|---|---|---|---|---|
| Дт/From | 5129071550 | ӨРНӨХГОЛОМТ | 150,000.00 MNT | 1.00 |
| | / Нэг зуун тавин мянган төгрөг / | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No 05; Дансны/Картын дугаар Account/Card number 5176120446 | Банкны нэр Bank Name Хаан банк; Нэр/Name МТА.ТАТВАР | 150,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
2230602306319; 5348013; 99904487

*Хатуу хог хаягдлын гэрээ*





*Бохирын цооног /10,20,40тн/*



**Хамтран ажиллах гэрээ**

Улаанбаатар Хот 2023-5-8 Огноо

Нэг талаас ________Сан гум ххк [illegible] / цаашид “А”тал гэнэ/, түүнийг төлөөлж ____________ Нөгөө талаас Өрнөх Голомт ХХК / цаашид “Б” тал гэнэ/, түүнийг төлөөлж ____________
Бид дараах нөхцөлоор энэхүү гэрээг байгуулав.

**1.Нийтлэг үндэслэл**

1.1. Гэрээний талууд [illegible] 121,000 [illegible] чиглэлээр [illegible] хэлбэрээр хамтран ажиллана.
1.2. Хамтран үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой хөрөнгийн эх үүсвэрийг талууд дараахь байдлаар хариуцан гаргана. / Хөрөнгийн төрөл, бэлэн болгох хугацаа зэргийг тодорхой заана/.
- “А”тал
- “Б”тал
1.3. Хамтран үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг талууд дараахь байдлаар хариуцан зохион байгуулна. / хийх ажлын чиглэл, төрөл,хийгдэх хугацааг заана/:
- “А”тал
- “Б”тал
1.4. Гэрээний хугацаа 1 жил байна. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгэж болно.

**2. Хамтын ажиллагааны удирдлага, хяналт**

2.1. Энэхүү гэрээний 1.1.-д заасан чиглэл хэлбэрийн хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг дараахь журмаар удирдан явуулна / дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно/.
- “А”тал нь дангаар төлөөлөх
- “Б” тал дангаар төлөөлөх
- “А” болон “Б” талууд хамтран
- “А”болон “Б” талууд өөр этгээдийн томилох замаар
2.2. Хамтын ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлж буй тал хэрэгжүүлсэн ажлын үр дүн, хөрөнгө мөнгөний зарцуулалтыг [illegible] бүрийн хугацаанд тогтмо тайлагнах үүрэгтэй.



2.3. Гэрээний аль ч тал гэрээний хэрэгуилт, бусад талуупын гэрээний талаархи үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
2.4. Гэрээний аль нэг тал бусад шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой өөрийн хийсэн ажлын талаар тайлэн тавих үүрэгтэй.

**3. Эд хөрөнгө**

3.1. Хамтын үйл ажиллагаатай холбоотой санаа, зардал, олсон орлого, өр, авлага, бусад зүйлс нь талуудын дараахь өмчлөлд байна. / дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно/.
- хамтран өмчлөх дундын өмч
- хэсгээр өмчлөх дундын өмчид дараахь хувь хэмжээгээр
3.2. Үйл ажиллагааны орлогоос бий болсон орлогын өөрт оногдох хэсгийг талууд өөрийн үзэмжээр захиран зарцуулна.
3.3. Хамтын үйл ажиллагаал үргэжлүүлэхтэй холбоотой гэрэх зардлыг талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
3.4. Хамтын ажиллагаанд зориулан хуримтлуулсан хөрөнгө мөнгийг зөвхөн хамтын ажиллагааны зорилгод нийцүүлэн зарцуулна.

**4. Хариуцлага**

4.1. Хамтын үйл ажиллагааны үр дүн, алдагдал хохирол, бусад этгээдийн өмнө үүссэн хариуцлагыг талууд дараахь зарчмаар хариуцна. / дараахь хувилбарын аль нэгийг сонго /
- хувь тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.
- хэсгээр өмчлөх хувь хэмжээний дагуу хариуцна.
4.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй үед нөгөө талдаа дараахь торгууль эсхүл алданги төлнө / дараахь хувилбарын аль нэгийг сонго/ :
- үүргийн үнийн дүнгийн _ хувийн торгууль төонө.
- үүргийн гүцэтгэлийг хожимдуулсан хоног тутамд 0,5 хувийн / 0,5 –аас ихүй байх/ алданги төлнө.

**5. Бусад заалт**

5.1. Талууд зйл ажиллагаандаа Монгол улсын иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.
5.2. Хамтын үйл ажиллагааны тайланг талууд жил тутам, явын тухай шаардлагатай тохиолдолд хэлэлцэж байна.
5.3. Талуудын хоорондын маргаан үүссэн тохиолдолд хариуцагчийн байнга газрын / шүүх, арбитр/ -аар шийдвэрлэнэ.



**6. Гэрээ хүчин төгөлдөр байх**

6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.
6.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд / дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно/
- харилцан тохиролцооны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.
- аль нэг тал нь 1 сарын өмнө урьдчилан мэдэгдэх замаар гэрээнээс татгалзаж болно. Энэ тохиолдолд тодорхой шалтгаан заагаагүй байж болно.
- онцгой нөхцөл шалтгаан бий болсон үед гэрээний аль нэг тал 1 сарын өмнө мэдэгдэж гэрээнээс татгалзаж болно. 6.3. Талууд тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

**7. Талуудын хаяг:**

**“А” тал** **“Б” тал**

Хаяг ,индекс: ______ Хаяг,индекс: ______
Утас: 99998868
Факс: ______ Факс: ______
Цахилгаан шуудангийн хаяг: ______ Цахилгаан шуудангийн хаяг: ______
Банкны харилцах дансны дугаар: ______ Банкны харилцах дансны дугаар: ______
Гарын үсэг ______ Гарын үсэг ______
Тамга,тэмдэг тамга,тэмдэг

*Бохир соруулах гэрээ*

2. Үйлдвэрийн агааржуулалтын ажиллагааг тогтмол шалган цэвэрлэгээ, засвар гүйцэтгэдэг.
3. “Энх цагийн үйлс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сард 1 удаа үйлдэрийн талбай, гадна талбайд ариутгал халдвэргүйжүүлэлтийг хийлгэдэг.



**Батлав**
**“Энх цагийн үйлс” ХХК**
**Захирал:.............Н.Баянмөнх**

**Ариутгал халвдаргүйтэл, шавьж мэрэгчийн устгал хийх, хамтран ажиллах гэрээ**

2023 оны 03-р сарын 29-ны өдөр №: 10 Улаанбаатар хот

Нэг талаас “Өрнөх Голомт ХХК”/цаашид “Захиалагч” гэх/ нөгөө талаас **5315859** тоот регистрийн дугаартай **“Энх цагийн үйлс”ХХК** ахуйн шавьж мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ үзүүлэгч/цаашид “Гүйцэтгэгч” гэх/ харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Гэрээний зорилго**

Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын шавьж, мэрэгч устгах, ариутгал халдваргүйтэлийн ажлыг стандартын шаардлага хангасан техник, технилогийн горим журмын дагуу явуулах мөн зөвшөөрөгдсөн ариутгал халдваргүйжүүлэлт, шавьж мэрэгчийн ахуйн өсөлт хөгжил, тархалтын багасгах бодис хэрэглэж хүний ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл боломжоог бүрдүүлэх зорилгоор энэхүү гэрээг байгуулав.

**Хоёр. Гүйцэтгэгч байгууллагын үүрэг**

2.1 Үйлчилгээний захиалгыг биеэр болон утсаар хүлээн авна.

2.2 Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээг олон улсын стандартын шаардлага хангасан хор, бодисоор технологи зааврын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.

2.3 Үйлчлэгч талын мэргэжилтний хамт үйлчилгээ хийлгэх өрөө тасалгааны тоо, талбайн хэмжээг тооцон гаргана.

2.4 Үйлчилгээнд хэрэглэх хор бодисын онцлог, аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгч, үйлчилгээ хийх өдөр, цаг, давтамжийг тогтоож, үйлчилгээний төлбөрийг тогтооно.

2.5 Үйлчилгээнээс хойш тодорхой хугацаанд эргэн тандалт хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлө.

2.6 Үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд нь барагдуулахыг шаардах эрхтэй.



2.7 Гэрээг үндэслэн ариутгал халдваргүйжүүлэлт хийх мэдээг 7 хоногийн өмнө үйлчлүүлэгч байгуулагад мэдэгдэж, урьдчилан бэлтгэлийг бүрэн хангасан байна.

**Гурав. Захиалагч байгууллагын үүрэг**

3.1 Үйлчилгээний захиалгыг утас болон биеэр очиж авна.

3.2 Үйлчилгээ хийлгэх газрын өрөө тасалгааны тоо, талбайн хэмжээг танилцуулж, үйлчлүүлэх талбай, үйлчилгээний төрөл, давтамжийг тогтоно.

3.3 Гүйцэтгэгч талд тухайн байгууллагад халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн эсэх, шавьж мэрэгчийн тархалт, төрөл зүйлийн талаар үнэн бодит мэдээлэл өгнө.

3.4 Гүйцэтгэгч байгууллагаас өгсөн үйлчилгээний өмнө ба дараа баримтлах зааврыг чанд мөрдөнө.

3.5 Үйлчилгээний чанар хэрэглэж буй хор бодисын чанарт хяналт тавина.

3.6 Үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь барагдуулна.

3.7 Байгууллагын нийт ажилчдад үйлчилгээнд хэрэглэсэн хор бодис, өгөөштэй болгоомжтой харьцах, үйлчилгээ хийсэн талын мэргэжилтний зөвшөөрөлгүй уг хор, бодис өгөөшт хүрэхгүй байх, хүүхэд гар хүрэхээс урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээг зохион байгуулна.

3.8 Үйлчилгээ хийсэн өдрөөс эхлэн хор бодисыг буцааж цуглуулах хүртэл хугацаанд хэрэглэсэн хор бодис, өгөөшийн хадгалалт, хамгаалалт, түүнтэй холбогдон гарах хариуцлагыг бүрэн хариуна.

3.9 Захиалагч байгууллага нь үйлчилгээ авснаас хойш 3 хоногийн дотор бэлэн ба бэлэн бусаар төлбөрийг хийнэ. Нэр: Энх цагийн үйлс” ХХК-ны 5058629616 дугаартай дансанд төлбөрийг хийнэ.

**Дөрөв. Гэрээний хугацаа, үнэ тариф**

4.1 2023 оны 03 сарын 29-ны өдөөс 2024 оны 03 сарын 29-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байгуулав.

4.2 Гэрээний хугацаа дууссан болович талууд гэрээг дуусгавар болгох тухай нөгөө талдаа албан ёсоор мэдэгдээгүй бол гэрээг цаашид ижил хугацаа нөхцөлтэйгээр сунгагдсанд тооцно.

4.3 Талууд хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрээг цуцлах, өөрчлөх бол 1 сарын өмнө албан ёсоор мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

4.4.1 Ариутгал халдваргүйжүүлэлт 1 $м^2$ талбайг ...200... төгрөгөөр,нийт ...500... $м^2$ талбайг............ төгрөгөөр халдваргүйжүүлэлт хийнэ. Бодисын нэр төрлөөс хамаарна.

4.4.2 Шавьж устгалд 1 $м^2$талбайг ...400... төгрөгөөр, нийт ...500... $м^2$ талбайг............ төгрөгөөр устгал хийнэ. Бодисын нэр төрлөөс хамаарна.

4.4.2 Мэрэгч устгалд 1 $м^2$ талбайг ...400... төгрөгөөр, нийт ...500... $м^2$ талбайг............ төгрөгөөр устгал хийнэ. Бодисын нэр төрлөөс хамаарна.

Дээрх ариутгал халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ нь хугацааны хувьд дараах нөхцөл байдалтай уялдан хийгдэнэ. Үүнд:

- ☐ Коронагийн цар тахлын үеийн нөхцөл байдалд 14 хоног тутамд
- ☑ Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт: Сар, улирал тутамд
- ☐ Болзошгүй аюул гамшиг, халдварт өвчин голомтлон гарсан үед дуудлагаар хийх: Гэрээний тарифын дагуу
- ☐ Хавар намрын улиралд эдэлбэр газрын хөрсөнд халдваргүйжүүлэлт хийх

**Тав. Хамтран хүлээх үүрэг ба хариуцлага**

5.1 Хоёр тал гарын үсэг зурж, тамга дарснаар гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээг 2% үйлдэнэ.

5.2 Ажил үйлчилгааний явцад хяналт тавих ажилтныг 2 талаас гаргаж ажлуулна.

5.3 Үйлчилгээний чанартай холбогдон гарсан санал гомдлыг 2 тал хэлэлцэж, шалтгааныг тогтоон хамтран шийдвэрлэнэ. Асуудлыг шийдээрлэх боломжгүй бол хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

**Гэрээ байгуулсан:**

| Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж: | Захиалагч байгууллагыг төлөөлж: |
|---|---|
| “Энх цагийн үйлс” ХХК-НЫ | “Өрнөх голомт” ХХК |
| Менежер: ............ | Захирал:............ |
| Утас: 9000-6510 | Утас: 99998868 |
| Хаяг: СХД-ийн 1-р хороо Гүнгэрваа Худалдааны төв 57 тоот | Хаяг: СХД дүүрэг 20 хороо Сонсголон 18332-09/4 |

*Ариутгал гэрээ*

**“Энх цагийн үйлс” ХХК**

**Халдваргүйжүүлэлт хийсэн тухай акт**

2023 он 03 сар 29 өдөр

Актын №: 0004791

Өрнөх голомт ХХК тус байгууллагын нийт 500 мкв бүхий талбайд халдваргүйжүүлэлтийн үйлчилгээг дараах хувь хэмжээ, стандартын дагуу гүйцэтгэсэн болно.

Үүнд:өрөөний агаар, обьектын хана, шал,хаалга, хаалганы бариулгэсэн гадаргуугийн бүх хэсэгт, мөн ширээ сандал, тавиур зэрэг өрөөн доторх эд зүйлст болон угаалгын өрөө, 00-ын өрөө, жорлон, гаднах орчин тус бүрд тохирох процентоор халдваргүйжүүлэлтийг явуулж доорх нэр төрлийн бодисуудыг зарцуулсан болно.

- ☑ Клорсепт 17 0,02 % -ийн уусмалаар ..500.. мкв талбайд,
- ☐ Жавельоны 0,03% ,0,06%-ийн уусмалаар ......... мкв талбайд,
- ☐ ДП-2 0,03%-ийн уусмалаар (мананцар үүсгэгч /автомакс) багжаар халдваргүйтгэл хийгдэв.

Ахуйн хортон шавж, мэрэгч устгалд:

- ☐ Жилью
- ☐ Ципокс
- ☐ Өгөөш тавьж устгал хийв.

Халдваргүйжүүлэлт хийгдсэний дараа өрөөний цонх салхивчийг онгойлгож агааржуулалтыг сайн хийх, цахилгаан хэрэгслийг чийг авахаас сэргийлэн 2 цагийн дараа асаах, Эд зүйлсийг 1-2 цагийн дараа цэвэр усаар эсвэл савантай усаар угааж цэвэрлэх. Энэ үедээ хамгаалах бээлий, маск зэргийг зүүж байхыг анхааруулан, холбогдох зөвлөгөө зааврыг өгч үйлчилсэн болно.

Гүйцэтгэсэн менежер: 1.........................................

Халдваргүйжүүлэгч: 2.........................................

Хавсаргасан баримт: 1. Байгууллагын гэрээ №:............

2.Зарлагын баримт №................

Хяналт тавьж зааварчилгаа өгсөн:

Эрүүл ахуйч:............................

Хамт байлцаж хянасан:...............................

**“ХУНТ ХАЙРХАН” ХХК-аас АХШМУ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙСЭН АКТ**

Улаанбаатар хот № 10/22 2023 оны 10 сарын 04 өдөр

Танай Өрнөх Голомт ХХК-ын нийт 300 $м^2$ талбайд халдваргүйжүүлэлтийг Ирланд улсын **Клорсепт-17 0,02%,** Англи улсын **Просан 0,02%,** Францын **Жавельон 0,02%,** шавьжгүйтгэлийг ОХУ-ын **Фас, Суферфас,** БНХАУ-ын **Жилью-Эмульсэн бодис-5%** мэрэгчгүйтгэлийг БНХАУ-ын **Бромделион 5%**-аар өгөөшилж устгах ба халдваргүйжүүлэлтийн 3-н цэгт үйлчилгээг ОХУ, БНХАУ-ын **Гипохлорид кальцийн 47-52%**-ийн уусмалаар гадна талбайд хэрэглэнэ.

Халдваргүйжүүлэлтийг уусмалаар агаар, дусал, гарнизын аргаар хийж, кассын орлогын ордер, нэхэмжлэх /зур/ хийж баримтуудыг хавсаргав.

Байгууллагын төлөөлөгч нь АШМУХҮйлчилгээг эрүүл ахуйн шаардлага хангасан бодисоор хийж байгаа эсэхэд хяналт тавьж үнэлгээ дүгнэлт өгч баталгаажуулна.

Ариутгалыг МУ-ын MNS 51-61-3-2002 стандартын дагуу эрүүл ахуйн шаардлага хангасан бодисоор хийж гүйцэтгэв. Халдваргүйжүүлэлтийн үйлчилгээний үр дүнд шавж, мэрэгчийн төрөл зүйлд тандалт судалгаа хийж тэмдэглэх ..........................................

Байгууллагыг төлөөлж..........................................

| | |
|---|---|
| Тандалт хийсэн Биологич ........................ | /Ц.Цэрэнханд/ |
| Химич ........................ | /Я.Нарантуяа/ |
| Зөвлөх эрүүл ахуйч эмч ........................ | /Н.Уртнасан/ |
| Тархвар судлаач эмч ........................ | /Д.Бямбадорж/ |
| Эрүүл ахуйч эмч ........................ | /Б.Алтанцэцэг/ |
| ХАБЭА ажилтан, ариутгагч ........................ | /Ж.Сандагдорж/ |



6.1.3. Форс мажорын улмаас бараа бүтээгдэхүүн устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн өгөх хүртэлх эрсдлийг худалдагч тал, шилжүүлэн авсанаас хойшихийг худалдан авагч тал хариуцна.

**Долоо. Гэрээ сунгах, цуцлах**

7.1.1. Гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө талууд гэрээг дүгнэх ба аль нэг талаас гэрээг цуцлах санал гаргаагүй бол гэрээг дахин нэг жилийн хугацаагаар сунгасанд тооцно.
7.1.2. Худалдан авагч нь цэвэр ус худалдан авсан төлбөрөө хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 1 сараас дээш хугацаагаар төлөөгүй бол худалдагч гэрээг цуцлах эрхтэй.
7.1.3. Энэхүү гэрээний 2.2-т заасан шинэ үнийн талаар талууд тохиролцоогүй бол гэрээ цуцлагдсанд тооцно.
7.1.4. Талууд гэрээ цуцлах тухай үндэслэл бүхий саналаа хуанлийн 7-оос доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

**Найм.Бусад зүйл**

8.1.1. Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, талууд тус тусын хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж, гэрээний хугацаа дуусcанаар дуусгавар болно.
8.1.2. Талууд энэхүү гэрээтэй холбоотой гарсан аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ. Хэрэв маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд гэрээнээс үүдэн гарсан аливаа маргааныг Монгол Улсын Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэнэ. Шүүхийн үйл ажиллагаатай холбогдон гарах бүхий л зардлыг буруутай этгээд хариуцна.
8.1.3. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүргээ аль нэг талынхаа албан ёсны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр аливаа нэг гуравдагч этгээдэд хэсэгчилэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй болно.
8.1.4. Гэрээний хугацаа, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Гэрээний хүчинтэй хугацаанд гэрээнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

**ЦЭВЭР УСНЫ БАЛЛОН АШИГЛАХ / ХУДАЛДАН АВАХ / ТУХАЙ ГЭРЭЭ (ДЭД ГЭРЭЭ)**

Нэг талаас “.....” ХХК түүнийг төлөөлж Худалдааны төлөөлөгч ..... /цаашид “Өмчлөгч” тал гэх/ “Өрнөх голомт” ХХК, Хувь хүн-ийг төлөөлж ..... /цаашид "Ашиглагч" тал гэх/, /хамтад нь “талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 399-341 дүгээр зүйлүүд болон талуудын хүсэл зоригийг тус тус үндэслэн харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1.1 Энэхүү гэрээгээр “ ” ХХК /өмчлөгч тал/ нь гэрээний хавсралтад заасан,өөрийн өмчлөлийн цэвэр усны баллоныг



“.....” /худалдан авагч тал/-д цэвэр ус худалдах, худалдан авах гэрээ байгуулсантай холбогдуулан, **/байршуулсан баллоныг 2-3 сарын хугацаанд үндсэн үнийг хуваан төлж барагдуулах/**ашиглуулахаар хүлээлгэн өгөх, худалдан авагч тал нь цэвэр усны баллоныг хүлээн авч зориулалтын дагуу ашиглаж, төлбөр барагдуулж дуусахад / баллон худалдан авагч талын өмч болох харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Талуудын эрх, үүрэг**

2.1.1. Өмчлөгч тал нь, олгосон хүний нэрийг бичиж ашиглагч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

2.2. Баллоны үнийн тариф:

| Баллоны хэмжээ /л/ | баллон үнэ /төгрөг/ |
|---|---|
| 19 /л/ | 25000 |

2.2.1. Баллоны хэвийн ашиглалтыг хэрэглэгч өөрөө хариуцна.
2.2.2. Ашиглагч тал нь өмчлөгч талын лого бүхий цэвэр усны баллоныг эвдэж, гэмтээж, үрэгдүүлэхгүй байх үүрэгтэй ба баллоныг гуравдагч этгээдэд шилжүүлэх болон худалдахыг хориглоно.
2.2.3. Цэвэр усны баллоныг хатуу биетээр цохих, үзүүртэй зүйлсээр хатгах буюу цоолох, өөрийн хэвийг алдагдуулах, баллонд цэвэр уснаас өөр шингэн хийх, зориулалтын бусаар ашиглахыг хатуу хориглоно.
2.2.4. Ашиглагч тал нь энэ гэрээний 2.3, 2.4-г зөрчиж өмчлөгчид хохирол учирсан тохиолдолд гэм буруутай эсэхээс үл хамааран баллоны үнийг зах зээлийн үнээр нөхөн төлж, тухайн баллоны зах зээлийн үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн торгуулийг нэмж төлнө.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| Худалдагчийг төлөөлж: | Худалдан авагчийг төлөөлж: |
|---|---|
| “ ” ХХК-ний Худалдааны төлөөлөгч: ..... | “Өрнөх голомт ХХК” ХХК, Хувь хүн /аль нь болохыг доогуур зурах/ |
| Хаяг: СХД, 20-р хороо, Сонсголон-23, Гранд хатан туул ХХК | Хаяг: СХД 20р хороо Сонсголон |
| Утас/ факс: 70173386 | Утас/факс: |
| Дансны дугаар: | Ажил/утас: ..... |



Гранд Хатантуул ХХК

ЗАРЛАГЫН БАРИМТ № 5348013



Гранд Хатантуул ХХК

ЗАРЛАГЫН БАРИМТ №

*Усны гэрээ*



ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар : 23-2635

| Дээжийн дугаар | Дээжийн нэр | Үйлдвэрлэсэн улс | Хүчинтэй хугацаа | Дээжийн тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 12580 | Пюрэ ус 5л | Монгол Улс | 2024/05/28 | 1 ш |
| 12581 | Баллон ус 19л | Монгол Улс | 2024/05/18 | 1 ш |
| 12582 | Хатан туул цэвэр ус 0,5л | Монгол Улс | 2024/06/18 | 4 ш |
| 12583 | Хатан туул цэвэр ус 1,5л | Монгол Улс | 2024/06/18 | 2 ш |

| Дээжийн дугаар | Шинжилгээний аргын стандарт | Шинжилсэн үзүүлэлтийн нэр | Шаардлага | Шинжилгээний дүн |
|---|---|---|---|---|
| 12580 | MNS ISO 7150:2006 | Аммони (**) | илрэхгүй | 0,0 мг/л |
| | ЗАХХСХЛ.7.2.82 | Кальци (**) | 20,0 мг/л ихгүй | 2,01 мг/л |
| | ЗАХХСХЛ.7.2.86 | Магни (*) (**) | 5,0 мг/л ихгүй | 0,0 мг/л |
| | MNS 4430:2005 | Нийт төмөр (**) | 0,2 мг/л ихгүй | 0,0 мг/л |
| | MNS ISO 7890:3:2001 | Нитрат (**) | 1,5 мг/л ихгүй | 0,78 мг/л |
| | MNS 6779:2019 | Нитрит (**) | илрэхгүй | 0,0 мг/л |
| | MNS ISO 10523:2001 | pH (**) | 5,5-7,5 | 6,39 |
| | MNS 6271:2011 | Сульфат (**) | 15,0 мг/л ихгүй | 0,0 мг/л |
| | ЗАХХСХЛ5.4.50 | Хатуулаг (**) | 2,0 мг-экв/л | 0,25 мг-экв/л |
| | MNS 4424:2005 | Хлорид (**) | 15,0 мг/л ихгүй | 2,85 мг/л |
| | MNS 4423:1997 | Хуурай үлдэгдэл | - | 180 мг/л |
| | MNS ISO 7888:1999 | Цахилгаан дамжуулах чанар | - | 0,007 мСм/см |
| | MNS ISO 8467:1999 | Фосфат | - | 0,0 мг/л |
| | MNS ISO 6222:1998 | БЕЕТ | 1мл-т 20-оос ихгүй | БЕЕТ 0 |
| | MNS ISO 9308-1:1998 | Гэдэсний бүлгийн нян | 100мл-т илрэхгүй | Гэдэсний бүлгийн нян илрээгүй. |
| | MNS ISO 19250:2013 | Salmonella spp | 25мл-т илрэхгүй | Salmonella spp илрээгүй. |
| 12581 | MNS ISO 7150:2006 | Аммони (**) | илрэхгүй | 0,0 мг/л |
| | ЗАХХСХЛ.7.2.82 | Кальци (**) | 20,0 мг/л ихгүй | 6,04 мг/л |
| | ЗАХХСХЛ.7.2.86 | Магни (*) (**) | 5,0 мг/л ихгүй | 3,63 мг/л |
| | MNS 4430:2005 | Нийт төмөр (**) | 0,2 мг/л ихгүй | 0,0 мг/л |
| | MNS ISO 7890:3:2001 | Нитрат (**) | 1,5 мг/л ихгүй | 0,80 мг/л |





*Баллонтой усны ерөнхий химийн шиинжилгээний дүн*

### 2.1.4. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ

Тус онд хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлыг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Ахуйн гаралтай хог хаягдлын цэгийг шинэчлэн байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
2. Үйлдвэрийн талбайн хөрснөөс 1 дээж авч итгэмлэгдсэн лабораториор шинжлүүлсэн /ОХШХ тусгав/.
3. Үйлдвэрийн гадна талбайн цэвэрлэгээг гүйцэтгүүлэн ажилладаг.







*Арчилгаа, цэвэрлэгээний ажил хийгдэж буй байдал*

## ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛЫН БИЕЛЭЛТ

Манай байгууллага нь тус онд эзэмшил талбайд ногоон байгууламж бий болгох, тохижилтийн ажлын хүрээнд үйлдвэрийн байрны гадна цэцгийн мандал, хүлэмж байгуулан орчны тохижилтын ажил болон ажилчдын хүнсний хэрэглээний ногоог өөрсдийн хүлэмжинд тариалан ашиглаж байна.

Хүснэгт 2. Орчны тохижилт, ногоон байгууламжын төлөвлөгөөний биелэлт

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Цэцгийн мандал | Үлйдвэрийн хашаанд | 100% |
| 1 | Орчны үзэмжийг сайжруулах, тоосжилтоос сэргийлэх, мод тарих | Мод тарих | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Сонгинохайрхан дүүрэг, 21-хороонд байрлах Инчон мөрөөдлийн төгөлд 20ш шинэс мод тарьсан | 100% |
| 2 | | Хүлэмж | Манай байгууллага нь өөрсдийн талбайдаа хүлэмж байгуулан дотор нь хүнсний ногоо тариалан ажилчдын хүнсэнд ашигладаг. Ногоон байгууламжийн арчилгаа тордолтыг тогтмол гүйцэтгэж байна. | 100% |








*Үйлдвэрийн гадна ногоон байгууламж*







*Хүлэмжийн зураг*

## ДӨРӨВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай байгууллагын хүрээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг тоног төхөөрөмжтөй харьцаж ажилладаг тул байгууллагын хөдөлмөр аюулгүй байдал анхаарч ажилладаг билээ. Иймд ч байгууллагын үйл ажиллагаанд Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандартуудыг баримтлан ажиллаж байна.

Үйлдвэрт осол, эрсдэлийн менежмент төлөвлөгөөг 2 чиг үүргээр баримтлан ажилладаг. Үүнд:

1. Ажилчдын аюулгүй байдал, хамгаалах хэрэгсэл, сургалт
2. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
3. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг

Тус онд дээрх 3 чиг үүргийг баримтлан дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Хүснэгт 3. Осол, эрсдлийн менежмент төлөвлөгөөний биелэлт

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах | Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ажиллагааг өдөр тутам тогтмол шалгаж мэргэжлийн хамт олноор жилд 1 удаа тоног төхөөрөмжтөй харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулж байна. | % |
| | Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт | | |
| | Үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт | | |
| | Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах | Үйлдвэр болон төслийн талбайд гал унтраах бүрэн тоноглогдсон сараалж 1, сануулга самбар 4, ХАБЭА самбар 6 байршуулсан. | % |
| | Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах | “Гэмтэл согог судлалын үндэсний төв” -тэй байгуулсан гэрээний дагуу нийт ажилчдад жилд 1удаа шинжилгээнд хамруулдаг. | % |



*Гал унтраах хэрэгсэл*










*Хөдөлмөр аюулгүй байдлын хувцас хэрэгсэл*

Үйлдвэрт ажиллаж буй ажилчдад өдөр тутамдаа резинэн бээлий, даавуун бээлий, нэг удаагийн амны хаалтаар хангадаг. Мөн дараахь хамгаалах хэрэгслээр тодорхой хугацааны давтамжтай элэгдэл харгалзан хангаж байна.














*Хөдөлмөр аюулгүй байдлын хувцас хэрэгсэл*



БАТЛАВ:
"ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"-н ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ ______ Э.ГАЛБАДРАХ

БАТЛАВ:
"ӨРНӨХ ГОЛОМТ" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ______ Л.ГАНХУЯГ

**ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

2023 оны 05 сарын 31 Улаанбаатар хот

Нэг талаас "ӨРНӨХ ГОЛОМТ" ХХК-ийг төлөөлж захирал албан тушаалтай Л.Ганхуяг /цаашид "А" тал гэх/ нөгөө талаас "Гэмтэл Согог Судлалын Үндэсний төв"-ийн ерөнхий захирал албан тушаалтай Э.Галбадрах /цаашид "Б" тал гэх/ нар дор дурьдсан нөхцөлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь "Өрнөх голомт" ХХК болон "ГССҮТ"-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний хугацаа, төлбөрийн нөхцөл

2.1 Энэхүү гэрээ нь 2023 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 2025 оны 06 дугаар сарын 01-ны өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Гэрээг талууд тохиролцсоны үндсэн дээр цуцалсан бол тэр үеэс гэрээний хугацаа дуусгавар болно.
2.2 Гэрээний үргэлжлэх хугацаа: 2 жил
2.3 "Өрнөх голомт" ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 25 үндсэн ажилтанд 3,750,000 сая төгрөгтэй дүйцэхүйц үйлчилгээг авах, уг санхүүжилтыг ГССҮТөвийн дотоод тохижилт хийж буй компаны дансанд шилжүүлэх . Уг үнийн дүнд ГССҮТ-өөс дараах үйлчилгээгээр хийхээр тохиролцов.
**Үүнд:**
- "Өрнөх голомт" үндсэн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд багтаан үзүүлэхээр нийт 70 хүн./Урьдчилан сэргийлэх үзлэгт: 5 нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, Ерөнхий цусны шинжилгээ, Биохими, Витамин Д, ДОХ, , Шээсний шинжилгээ, Хэвлийн ЭХО, Зүрхний цахилгаан бичлэг, Рентген багтана. Шаардлагатай тохиолдолд компьютер томограф, MRI хийгдэнэ./
- Эрүүл мэндийн 4 сургалт ажилтнуудад орно.

Гурав. Гэрээний нөхцөл

3.1 Гэрээний хугацааг талууд тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.
3.2 Гэрээний аль нэг тал нь гэрээний үүргээ зөрчсөний улмаас бусдад болон гэрээний талуудад хохирол учруулсан бол хохирлыг тухайн үед барагдуулах.
3.3 Талууд тухайн гэрээт хугацаанд эрхээ ашиглах боломжгүй болсон тохиолдолд энэ тухайгаа нөгөө талдаа урьдчилан мэдэгдэх ба талууд тохиролцсоны үндсэн дээр боломжит хугацаанд нөхөн олгож болно.

Дөрөв. А талын эрх, үүрэг

4.1 Үзлэгт орох нийт ажилчдыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан байна.
4.2 Бусад эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа болон өндөр өртөгт шинжилгээний бүртгэлд хамрагдаагүй байх.
4.3 Тухайн тохиролцсон хугацаанд үйлчилгээ авахдаа цагаасаа хоцрохгүй байх .
4.4 А тал ГССҮТөөөр үйлчлүүлэхдээ заасан хуваарийн дагуу үйлчлүүлэх үүрэгтэй.
4.5 А тал ГССҮТөөөр үйлчлүүлэхдээ байгууллагын тавилга, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэрэгслийг ариг гамтай ашиглах, эвдэлж гэмтээсэн тохиолдолд үнийг төлж, хохиролгүй болгох үүрэгтэй.

Тав. Б талын эрх, үүрэг

5.1 Б тал нь А талд үйлчилгээ авсан бүх хүний эрүүл мэндийн ерөнхий дүгнэлтийг гаргаж өгнө.
5.2 Оношлогоо шинжилгээнд орохдоо эмчийн өгсөн зөвлөмжийн дагуу өлөн байхаас гадна согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байх, төвийн үйлчилгээний дотоод журмыг баримтлан соёлтой боловсон үйлчлүүлэх үүрэгтэй.
5.3 А тал заалнд хог хаяхгүй, архи, тамхи хэрэглэхгүй, зүй бус үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй.
5.4 Б тал нь А талд хүлээсэн үүргийн дагуу энэхүү гэрээний 2.3-т заасан үзлэг шинжилгээг товлосон цаг хугацаанд хийх үүрэгтэй.
5.5 Шаардлагатай тохиолдолд хийгдэх компьютер томограф, MRI шинжилгээг А талын эрх бүхий ажилтны албан тоотыг үндэслэн бүртгэж Б тал дараалал хүлээлгэхгүйгээр үйлчилгээг үзүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1 Гэрээнд дурдагдсан цаг хугацаанд өөрчлөлт орвол талууд хэлэлцэн тохиролцож шийдвэрлэнэ.

**Гэрээ байгуулсан:**

**"А" ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:** ______

**"Б" ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:** ______ **Л.Ганхуяг**

*Эрүүл мэндийн үзлэг хийх гэрээ*

# ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний биелэлт

| **Болзошгүй сөрөг нөлөөлөл** | **Нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | **Биелэлт** | **Хувь** |
|---|---|---|---|
| Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох | Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | Тус онд хатуу хог хаягдлын цэгийг хатуу хучилттай ангилан ялгадаг таславчтай битүү байгууламж байгуулахаар төлөвлөн талбайг бэлтгэн ажиллаж байна. | 20% |
| Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй | Шингэн хаягдлыг зайлуулж буй цэвэршүүлэх байгууламжтай холбогдож буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих | Ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг 60тн 2ш, 10тн 2ш төмөр доторлогоотой бохирын цооногт хадгалан “Сан гум” ХХК-тай байгуулсан гэрээгээр соруулан зайлуулж байна. | 100% |
| Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй | Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах | Уурын зуух нь хаягдал самрын ясыг шатааж галладаг. Хорт утаа бага ялгаруулдаг | 100% |

# ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

| № | Хянах үзүүлэлтүүд | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Агаарын чанар: Агаарын бохирдлын шинжилгээ, дуу чимээний хэмжилтийг хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар./ | Үйлдвэрийн хашаан дотор 2023.09.18-ны өдөр ЦУОШГ-ын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораториор хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээний хэмжилтыг 20 минутын турш хийлгэсэн. | 100% |
| 2 | Усны хяналт шинжилгээ | . Унд ахуйн хэрэгцээнд “Хатан туул”ХХК тай гэрээ байгуулан баллонтой худалдаж авдаг. Баллонтой усны дээжийг хавсаргав. | 100% |
| 3 | Хөрсний төлөв байдал, бохирдол | Үйлдвэрийн байрны гадна талбайн өнгөн хөрснөөс 2023.04.05-ны өдөр дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид агрохими, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн. | 100% |

## 6.1. Агаарын шинжилгээ

Үйлдвэрийн хашаан дотор 2023.09.19-ны өдөр ЦУОШГ-ын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораториор хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээний хэмжилтыг 20 минутын турш хийлгэсэн. Тус шинжилгээний дүнгээр Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй буюу бохирдолгүй гарсан.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023/А-255
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Өрнөх Голомт" ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2023.09.18
Сорьцын тодорхойлолт : СХД 20-р хороо ноос ноолуур самнах үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2023.09.19
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м³ | | | ДБА |
| 1 | Ноос ноолуур самнах үйлдвэр дотор | IX/18 | 14:50 | 0.013 | 0.018 | 0.382 | 75 |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Ажлын байрны орчин.Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015 | | | | 2 | 2 | 2 | - |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Шуугианы норм.Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 | | | | | | | 85 |

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

*Агаарын шинжилгээний дүн*

## 6.2. Усны хяналт шинжилгээ

Унд ахуйн хэрэгцээнд "Хатан туул"ХХК тай гэрээ байгуулан баллонтой худалдаж авдаг. Баллонтой усны дээжийг хавсаргав.



7/2/2023 GASI-LIMS

МХЕГ-ын Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний лавлагаа лабораторийн Ерөнхий захирлын 2018 оны 05 сарын 09-ний өдрийн А/20 дугаар тушаалын хавсралт Маяг 01-65

**МХЕГ-ЫН ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИ**

*Улаанбаатар 17042, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 75.*

*Утас: 70005972, Факс: 70006946*

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**
*CERTIFICATE OF ANALYSIS*

**Бүртгэлийн дугаар** Registration number : 23-2635

**Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр :** Гранд хатан туул
The name of customer's request for analysis

**Дэд лабораторийн нэр** Name of the sub laboratory : Хими, хор судлалын лаборатори; Нян судлалын лаборатори

| Дээжийн тодорхойлолт Sample description | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Дээжийн дугаар Sample number | Дээжийн нэр Name of sample | Цувралын дугаар Batch number | Үйлдвэрлэсэн улс The country of original manufacture | Хүчинтэй хугацаа Date of expiry | Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample |
| 12580 | Цэвэр ус 5л | | Монгол Улс | 2024/05/28 | 1 ш |
| 12581 | Баллон ус 19л | | Монгол Улс | 2024/05/18 | 1 ш |
| 12582 | Хатан туул цэвэр ус 0,5л | | Монгол Улс | 2024/06/18 | 4 ш |
| 12583 | Хатан тууд цэвэр ус 1,5л | | Монгол Улс | 2024/06/18 | 2 ш |

| Хүлээн авсан огноо Date of receipt | Шинжилгээ дууссан огноо Date of test completion | Хэвлэсэн огноо Date of issue of the report |
|---|---|---|
| 2023 он 06 сар 18 өдөр | 2023 он 06 сар 30 өдөр | 2023 он 07 сар 03 өдөр |

| Дээжийн дугаар Sample number | Шинжилгээний аргын стандарт Method of analysis | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter, unit | Шаардлага Test specification, unit | Шинжилгээний дүн Test results |
|---|---|---|---|---|
| 12580 | MNS ISO 7150:2006 | Аммони (**) | илрэхгүй | 0,0 мг/л |
| | ЭАХХСХЛ.7.2.82 | Кальци (**) | 20,0 мг/л ихгүй | 2,01 мг/л |
| | ЭАХХСХЛ.7.2.86 | Магни (*) (**) | 5,0 мг/л ихгүй | 0,0 мг/л |
| | MNS 4430:2005 | Нийт төмөр (**) | 0,2 мг/л ихгүй | 0,0 мг/л |
| | MNS ISO 7890:3:2001 | Нитрат (**) | 1,5 мг/л ихгүй | 0,78 мг/л |
| | MNS 6779:2019 | Нитрит (**) | илрэхгүй | 0,0 мг/л |
| | MNS ISO 10523:2001 | pH (**) | 5,5-7,5 | 6,39 |
| | MNS 6271:2011 | Сульфат (**) | 15,0 мг/л ихгүй | 0,0 мг/л |
| | ЭАХХСХЛ5.4.60 | Хатуулаг (**) | 2,0 мг-экв/л | 0,25 мг-экв/л |
| | MNS 4424:2005 | Хлорид (**) | 15,0 мг/л ихгүй | 2,85 мг/л |
| | MNS 4423:1997 | Хуурай үлдэгдэл | - | 180 мг/л |
| | MNS ISO 7888:1999 | Цахилгаан дамжуулах чанар | - | 0,007 мСм/см |
| | MNS ISO 8467:1999 | Фосфат | - | 0,0 мг/л |
| | MNS ISO 6222:1998 | *ББЕТ* | 1мл-т 20-аас ихгүй | ББЕТ 0 |
| | MNS ISO 9308-1:1998 | Гэдэсний бүлгийн нян | 100мл-т илрэхгүй | Гэдэсний бүлгийн нян илрээгүй. |
| | MNS ISO 19250:2017 | *Salmonella spp* | 25мл-т илрэхгүй | Salmonella spp илрээгүй. |
| 12581 | MNS ISO 7150:2006 | Аммони (**) | илрэхгүй | 0,0 мг/л |
| | ЭАХХСХЛ.7.2.82 | Кальци (**) | 20,0 мг/л ихгүй | 6,04 мг/л |
| | ЭАХХСХЛ.7.2.86 | Магни (*) (**) | 5,0 мг/л ихгүй | 3,63 мг/л |
| | MNS 4430:2005 | Нийт төмөр (**) | 0,2 мг/л ихгүй | 0,0 мг/л |
| | MNS ISO 7890:3:2001 | Нитрат (**) | 1,5 мг/л ихгүй | 0,80 мг/л |

gasi.shinjilgee.mn/generalTestPage?sid=0# 1/3

*Зураг 19.* Усны шинжилгээний дүн

## 6.3. Хөрсний шинжилгээ

Үйлдвэрийн байрны гадна талбайн өнгөн хөрснөөс 2023.04.05-ны өдөр дээж авч "Инженер геодези" ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид агрохими, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн.

Шинжилгээний дүнгээр үйлдвэрийн талбай нь хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламжаар бага, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хүнд металлийн бохирдолгүй хөрс байна гэж гарсан байна.

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 23/515**

**Дээж авсан огноо:** 2023 он 04 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2023 он 04 сарын 05-07
**Дээж авсан газрын нэр:** Улаанбаатар хот, СХД-20-р хороо, ноос ноолуур самнах үйлдвэр
**Координат:** -
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** “Өрнөх Голомт”ХХК
**Харилцах утас:** 99019797

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг ,% | $CaCO_2$ ,% | Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элемэнтүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | 23/956 | Хөрс-1 | - | 8.05 | 0.14 | 0.295 | 3.54 | 0.32 | 21.4 | 14.0 | 3.5 | 34 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 23/956 | Хөрс-1 | - | 35.5 | 39.6 | 5.2 | 4.0 | 2.5 | 13.3 | 19.7 |

***Хөрсний хүнд металл***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | *Хүнд металл мг/кг* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 23/956 | Хөрс-1 | - | ND | ND | 28.4 | 10.6 | 58.2 | 0.11 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

***ND-not detect**

***Жич:** Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Л. Цагаандархи /MS.c/
Задлан шинжээч: О.Дагвийжалам /MS.c/

*Зураг 20. Хөрсний шинжилгээний дүн*

Үйлдвэрийн талбайд хийгдсэн 2023 оны орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд авсан дээжнүүдээс холбогдох стандарт давсан агууламж илрээгүй буюу үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинг бохирдуулсан нөлөөлөл одоогоор байхгүй байна.

# ДҮГНЭЛТ

Манай байгууллага нь ноос, ноолуур самнах үйлдвэр төслийг Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн 1.0 га талбайд үйл ажиллагааг явуулж байна. Үйлдвэр нь 2023 онд 55 тн орчим ноолуур самнан гаргасан.

Үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний 90 орчим хувийг гүйцэтгэн ажилласан ба хог хаягдлын менежмент төлөвлөгөөний хүрээнд хатуу хучилттай ангилан ялгах зориулалтын талбайг байгуулахаар бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.

2023 онд манай байгууллага нь байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөний хүрээнд нийт 2,795,000 орчим төгрөгийг зарцуулсан байна.

**“НҮРИ” ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг
Төв шуудан, шуудангийн хайрцаг-523
Утас: 95038214, 89785535
И-мэйл: nurixxk@yahoo.com

2023.10.23 № 24

танай ______________ -ны № ______________ -т

ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 83 зарлиг "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 2021 оны 56 дугаар зарлиг "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 27 дахь заалт "Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр орон нутагт ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх", ажлын хүрээнд ойн мэргэжлийн байгууллага "Нүри ХХК"-аар дамжуулан 33 дахь заалт "Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Өрнөх голомт ХХК нь Сонгино хайрхан дүүргийн 21 хороонд байрлах Инчон мөрөөдлийн төгөлд 20 ширхэг шинэс мод тарьсан нь үнэн болно.

ЗАХИРАЛ Х.ЛХАГВАЖАВ

УЛААНБААТАР ХОТ
НҮРИ ХХК
УБ 14 2781066

**БАТЛАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН**
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА........................................................................ /
Ц.УРАНЧИМЭГ/

**ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН.**
"ӨРНӨХ ГОЛОМТ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ................................................................................/
Л.ГАНХУЯГ/

# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ ОРШИХ "ӨРНӨХ ГОЛОМТ" ХХК-ийн ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НООС, НООЛУУР САМНАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5348013

**ХЯНАСАН:**
Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын
газрын мэргэжилтэн......................................................................../ П.Шинэцэцэг /

**БОЛОВСРУУЛСАН:**
"Өрнөх голомт" ХХК-ийн байгаль орчны
мэргэжилтэн................................................................................/С.Рэнцэнзоо/

**Улаанбаатар**
**2023**